



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 427

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 40,000,000.00 (дөчин сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга Н.Гантөмөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



0002083

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 10 дугаар сарын 9-ны өдрийн
 427 дугаар тогтоолын харсалт



**Дорнод аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн/ ашиглал тад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босгогтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	"Ландкрузер-100", суудлын, 01-05 ДОР, JT3HT05JY0090534	1999/1999	173340	40,000,000.00	40,000,000.00	0	0	2,500,000.00
	Нийт дүн			40,000,000.00 (дөчин сая)	40,000,000.00 (дөчин сая)	-	-	2,500,000.00 (хоёр сая таван зуун мянган)